



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/31

Хархорин сум

Эзэмшил газрын хэлбэр өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.6 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Орхон хороолол 15а тоотод байрлалтай Д.Алтансүх 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууцны зориулалтаар эзэмшиж байгаа 1200м2 газрыг тухайн зориулалтаар хэмжээ байршил өөрчлөхгүйгээр хэлбэрийг нь өөрчлөн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч "Д.Алтансүх"-д газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга) нарт даалгасугай.

3.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, газрыг зориулалтын дагуу эзэмших, газрын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төвлөрүүлэх, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг (Д.Алтансүх)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын газар эзэмшүүлэх тухай 2023 оны А/281 дугаар захирамжийн Д.Алтансүхтэй холбогдох хэсэг, 0000338610 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Б.БАТ-ЭРДЭНЭ

